



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2024
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn
Аудитор: Ж.Бүжинханд
Утас: 261740 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Лидер экаунт аудит" ХХК-
ийн захирал: П.Шаравхорол
Утас: 88112654 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.5.1 Төсвийн төлөвлөлт	19
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.1 Албан шаардлага	23
5.2 Зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЗЖАРГАЛ
ТАНАА

2025.02.27 № 07/856
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Санхүүгийн тайланд тусгагдсан он дамжсан газрын төлбөрийн нийт 86,076.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;
- Засварын ажил гүйцэтгүүлсэн 4 аж ахуйн нэгжийн нийт 25,600.0 мянган төгрөгийн гэрээг дүгнэж, ажлыг хүлээн аваагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 22 дугаар зүйлийн 22.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтууд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолд заасныг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсвийн захирагчаас 11,179.5 мянган төгрөгийн балансын үнэтэй, 7,744.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 18 нэрийн тавилга, эд хогшлыг Эдийн засгийн хөгжлийн яамны балансаас балансад шилжүүлсэн тавилга, эд хогшлын дансанд бүртгэж авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Алтанбулаг чөлөөт бүсийн Цахилгаан хангамжийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын санхүүжилтэд 4,000,000.0 мянган төгрөг батлагдаж, үүнээс барилга угсралтын ажлын гүйцэтгэлд 3,929,230.9 мянган төгрөг, техник хяналтын зардалд 45,929.4 мянган төгрөгийг зарцуулж, 24,839.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудал

Алтанбулаг чөлөөт бүсэд худалдаа үйлчилгээний чиглэлээр хөрөнгө оруулалт оруулах, хамтран ажиллахаар нийт 145 аж ахуйн нэгж, иргэн бүртгэлтэй байгаагаас байнгын үйл ажиллагаа эрхэлж байгаа 31 аж ахуйн нэгж, иргэн, бүтээн байгуулалт хийж байгаа 3 аж ахуйн нэгж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон


Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	275,987,809.49	150,482,012.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	72,200,058.00	24,839,623.40
312	Банканд байгаа бэлэн мөнгө	72,200,058.00	24,839,623.40
3121	Төгрөг	72,200,058.00	24,839,623.40
21311	Төрийн сангийн харилцах	72,200,058.00	24,839,623.40
33	АВЛАГА	192,269,548.00	114,864,986.00
335	Бусад авлага	192,269,548.00	114,864,986.00
3351	Байгууллагаас авах авлага	192,269,548.00	114,864,986.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,518,203.49	10,777,403.49
354	Хангамжийн материал	11,518,203.49	10,777,403.49
35410	Бичиг хэргийн материал	3,658,800.00	420,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	148,500.00	148,500.00
35440	Түлш шатах тослох материал	-	930,000.00
35470	Бусад хангамжийн материал	7,710,903.49	9,278,903.49
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,354,674,832.06	22,282,422,065.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,354,674,832.06	22,282,422,065.98
392	Биет хөрөнгө	14,186,983,632.06	17,314,895,665.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,144,924,971.64	19,217,125,029.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,121,679,566.92)	(5,985,880,156.56)
39203	Автотээврийн хэрэгсэл	5,750,000.00	5,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,750,000.00)	(5,750,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	330,286,814.50	330,286,814.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(273,226,454.50)	(275,192,974.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	77,438,672.67	88,618,214.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,975,272.33)	(80,075,574.46)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	92,214,467.00	4,020,014,313.00
39300	Биет бус хөрөнгө	5,167,691,200.00	4,967,526,400.00
39301	Программ хангамж	3,700,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,700,000.00)	(3,700,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,422,966,200.00	5,222,801,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(255,275,000.00)	(255,275,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,630,662,641.55	22,432,904,078.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	106,516,578.24	37,799,005.61
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	106,516,578.24	37,799,005.61
413	Өглөг	106,516,578.24	37,799,005.61
4131	Ажиллагсадтай холбогдсон өглөг	-	6,240,104.21
41310	ХХОАТ-ын өглөг	-	6,240,104.21
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	-
4136	Бусад өглөг	72,200,058.00	31,558,901.40
		34,316,520.24	

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	34,316,520.24	31,558,901.40
6	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,524,146,063.31	22,395,105,073.26
51	Засгийн газрын хувь оролцоо	19,524,146,063.31	22,395,105,073.26
511	Засгийн газрын оруулсан капитал	6,542,753,318.00	6,542,753,318.00
51101	Өмч: төрийн	6,542,753,318.00	6,542,753,318.00
512	Хуримтлагдсан үр дүн	12,668,571,131.23	15,539,530,141.18
51210	Өмнөх үеийн үр дүн	13,542,934,655.41	12,651,785,897.23
51220	Тайлант үеийн үр дүн	(874,363,524.18)	2,887,744,243.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	312,821,614.08	312,821,614.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	19,630,662,641.55	22,432,904,078.87

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон


Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,036,781,251.03	5,414,603,454.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,561,484.27	111,147,250.44
120	Нийтлэг татварын бус орлого	102,561,484.27	111,147,250.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,561,484.27	111,147,250.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,113,148.88	106,143,774.00
1200045	Үнэ төлбөргүй гарсан орлого	7,448,335.39	5,003,476.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934,219,766.76	5,303,456,204.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	934,219,766.76	5,303,456,204.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	934,219,766.76	5,303,456,204.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,911,144,775.21	2,326,694,410.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,911,144,775.21	2,326,694,410.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,871,540,624.15	2,217,364,190.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,389,769.79	1,043,343,067.18
210101	Үндсэн цалин	519,216,301.19	618,753,048.71
210102	Нэмэгдэл	102,308,923.27	229,402,654.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,421,189.12	139,983,037.52
210104	Урамшуулал	41,443,356.21	55,204,326.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	37,328,721.27	120,922,040.76
210201	Тэтгэврийн даатгал	25,003,749.76	79,313,040.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,797,871.63	10,842,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,183,378.63	4,761,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	653,331.71	5,201,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,690,389.54	20,804,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,036,113.40	52,021,600.00
210301	Гэрэл, цахилгаан	22,282,337.79	49,176,400.00
210302	Түлш, халаалт	31,012,042.61	-
210303	Цэвэр, бохир бус	2,850,873.00	2,845,200.00
210304	Байрны түрээс	3,890,860.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	4,318,664.80	5,927,368.25
210401	Бичиг хэрэг	1,971,506.80	2,356,300.00
210402	Тээвэр, шатахууны зардал	852,700.00	1,549,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,494,458.00	2,021,268.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,422,101.00	21,744,400.00
210604	Урсгал засвар	17,422,101.00	21,744,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,790,000.00
210702	Дотоод томилолтын зардал	-	2,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,908,912.65	95,092,368.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,450,618.00	79,845,461.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,960,000.00	1,923,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,040,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,014.00	99,357.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	605,080.65	827,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	666,200.00	12,396,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	878,136,341.24	875,523,346.52

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал	870,866,741.24	875,523,346.52
210904	Найдваргүй авлагын алдагдал	7,269,600.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,604,151.06	109,330,219.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,400,890.00	8,850,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,420,690.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	980,200.00	8,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,203,261.06	100,480,219.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,203,261.06	100,480,219.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(874,363,524.18)	3,087,909,043.95
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	200,164,800.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	200,164,800.00
6	НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(4)-(5)	(874,363,524.18)	2,887,744,243.95

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/төгрөгөөр/
			Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,044,610,561.00	5,476,938,584.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,793,771.00	173,482,380.00
120	Нийтлэг татварын бус орлого	85,793,771.00	173,482,380.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,793,771.00	173,482,380.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,793,771.00	173,482,380.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	958,816,790.00	5,303,456,204.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	958,816,790.00	5,303,456,204.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	958,816,790.00	1,303,456,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	3,999,999,904.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,044,610,561.00	1,476,938,680.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,044,610,561.00	1,476,938,680.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,005,006,409.94	1,367,608,460.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706,723,599.69	1,051,760,786.21
210101	Үндсэн цалин	448,467,330.21	621,058,337.93
210102	Нэмэгдэл	121,237,655.40	235,515,083.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	83,033,797.68	139,983,037.52
210104	Урамшуулал	53,984,816.40	55,204,326.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,011,824.20	130,861,240.76
210201	Тэтгэврийн даатгал	57,172,188.21	86,071,740.76
210202	Тэтгэмжийн даатгал	6,645,104.05	11,197,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,246,722.77	5,598,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,251,504.49	5,598,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,696,304.68	22,394,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,267,862.40	52,021,600.00
210301	Гэрэл, цахилгаан	50,124,005.40	49,176,400.00
210302	Түлш, халаалт	5,270,159.00	-
210303	Цэвэр, бохир ус	2,873,698.00	2,845,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,007,288.65	6,041,068.25
210401	Бичиг хэрэг	2,292,650.00	1,705,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,260,100.00	2,479,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,454,538.65	1,856,268.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,793,100.00	21,744,400.00
210604	Урсгал засвар	19,793,100.00	21,744,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,790,000.00
210702	Дотоод албан томилолт	-	2,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,999,135.00	102,389,365.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,461,321.00	89,729,958.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,960,000.00	1,923,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,614.00	99,357.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	715,000.00	827,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	666,200.00	9,809,450.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203,600.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	203,600.00	-

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,604,151.06	109,330,219.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,400,890.00	8,850,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,420,690.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,200.00	8,850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,203,261.06	100,480,219.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,203,261.06	100,480,219.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	3,999,999,904.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,047,360,338.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,047,360,338.60
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,047,360,338.60
220001	Барилга байгууламж	-	3,975,160,280.60
223001	Бусад хөрөнгө	-	72,200,058.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(4,047,360,338.60)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(47,360,434.60)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	72,200,058.00	72,200,058.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,200,058.00	24,839,623.40

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон


Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	13,542,934,655.41	20,398,509,587.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	13,542,934,655.41	19,524,146,063.31
Тайлант үеийн үр дүн	-	-	(874,363,524.18)	(874,363,524.18)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	12,668,571,131.23	19,524,146,063.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(16,785,234.00)	(16,785,234.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	12,651,785,897.23	19,507,360,829.31
Тайлант үеийн үр дүн	-	-	2,887,744,243.95	2,887,744,243.95
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	15,539,530,141.18	22,395,105,073.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,435,520,800.00	5,376,458,364.22	59,062,435.78	98.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,435,520,800.00	1,376,458,460.22	59,062,339.78	95.9
Бараа, үйлчилгээний зардал	1,425,710,800.00	1,367,608,460.22	58,102,339.78	95.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,099,733,600.00	1,051,760,786.21	47,972,813.79	95.6
Үндсэн цалин	667,717,300.00	621,058,337.93	46,658,962.07	93.0
Нэмэгдэл	268,048,000.00	235,515,083.81	32,532,916.19	87.8
Унаа, болон бусад нөхөн олговор	95,176,600.00	139,983,037.52	(44,806,437.52)	147.1
Урамшуулал	68,791,700.00	55,204,326.95	13,587,373.05	80.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,966,900.00	130,861,240.76	9,105,659.24	93.5
Тэтгэврийн даатгал	95,177,400.00	86,071,740.76	9,105,659.24	90.4
Тэтгэмжийн даатгал	11,197,400.00	11,197,400.00	-	100.0
ҮОМШӨ ний даатгал	5,598,700.00	5,598,700.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	5,598,700.00	5,598,700.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	22,394,700.00	22,394,700.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,021,600.00	52,021,600.00	-	100.0
Гэрэл цахилгаан	49,176,400.00	49,176,400.00	-	100.0
Цэвэр, бохир ус	2,845,200.00	2,845,200.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	6,274,800.00	6,041,068.25	233,731.75	96.3
Бичиг хэрэг	1,787,900.00	1,705,000.00	82,900.00	95.4
Тээвэр (шатахуун)	2,485,200.00	2,479,800.00	5,400.00	99.8
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,001,700.00	1,856,268.25	145,431.75	92.7
Эд хогшил худалдан авах	21,744,400.00	21,744,400.00	-	100.0
Урсгал засвар	21,744,400.00	21,744,400.00	-	100.0
Томилолт, зочны зардал	2,790,000.00	2,790,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	2,790,000.00	2,790,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	102,979,800.00	102,389,365.00	590,435.00	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,314,800.00	89,729,958.00	584,842.00	99.4
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,923,200.00	1,923,200.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	99,400.00	99,357.00	43.00	100.0
Мэдээллийн технологийн зардал	832,400.00	827,400.00	5,000.00	99.4
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,810,000.00	9,809,450.00	550.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	199,700.00	-	199,700.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	199,700.00	-	199,700.00	-

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ



Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,810,000.00	8,850,000.00	960,000.00	90.2
Бусад урсгал шилжүүлэг	9,810,000.00	8,850,000.00	960,000.00	90.2
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	9,810,000.00	8,850,000.00	960,000.00	90.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,000,000,000.00	3,999,999,904.00	96.00	100.0
Дотоод эх үүсвэрээр	4,000,000,000.00	3,999,999,904.00	96.00	100.0
Барилга байгууламж	4,000,000,000.00	3,999,999,904.00	96.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,435,520,800.00	5,376,458,364.22	59,062,435.78	98.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,303,456,300.00	5,202,975,984.22	100,480,315.78	98.1
Улсын төсвөөс санхүүжих	5,303,456,300.00	5,202,975,984.22	100,480,315.78	98.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	132,064,500.00	173,482,380.00	(41,417,880.00)	131.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	132,064,500.00	173,482,380.00	(41,417,880.00)	131.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	42	33	9	78.6
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	28	19	9	78.6
Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь Алтанбулаг чөлөөт бүсэд хуулийн хэрэгжилтийг хангуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа үйлчилгээний шинэ салбарыг нэмэгдүүлэх, транзит тээвэр, ложистикийг нэмэгдүүлэх зэрэг төрийн үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд бүртгэх, хасах;
- Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох;
- Төр, засгийн байгууллага, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн нийтлэг үйлчилгээг санхүүжүүлэх, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах, эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу олгох;

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 126 дугаар тогтоолын хавсралтаар чөлөөт бүсүүдийн Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 42 алба хаагчтай байхаар баталсан байна. тайлант онд 33 төрийн албан хаагч ажиллаж байна.

Алтанбулаг чөлөөт бүсэд худалдаа үйлчилгээний чиглэлээр хөрөнгө оруулалт оруулах, хамтран ажиллахаар нийт 145 аж ахуйн нэгж, иргэн бүртгэлтэй байгаагаас байнгын үйл ажиллагаа эрхэлж байгаа 31 аж ахуйн нэгж, иргэн, бүтээн байгуулалт хийж байгаа 3 аж ахуйн нэгж байна.

Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгодог бөгөөд архины тусгай зөвшөөрөл эзэмшдэг 35, тамхины тусгай зөвшөөрөл эзэмшдэг 31 аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба нь үйл ажиллагаандаа Чөлөөт бүсийн тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дугаар тогтоол, бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгож ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус захирагчийн ажлын албаны захирагчийн 2023 оны А/60 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,802,241.5 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	72,200.1	24,839.6	(47,360.5)
Авлага	192,269.5	114,865.0	(77,404.5)
Бараа материал	11,518.2	10,777.4	(740.8)
Үндсэн хөрөнгө	19,354,674.8	22,282,422.1	2,927,747.3
Нийт хөрөнгө	19,630,662.6	22,432,904.1	2,802,241.5
Өр төлбөр	106,516.6	37,799.0	(68,717.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,524,146.0	22,395,105.1	2,870,959.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	19,630,662.6	22,432,904.1	2,802,241.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 24,839.6 мянган төгрөг байна. Тус захирагчийн ажлын албаны харилцах дансны үлдэгдэл 24,839.6 мянган төгрөг нь Сэлэнгэ аймаг дахь цахилгааны өргөтгөлийн барилгын техникийн хяналтын үлдэгдэл байна.
- Авлага дансны үлдэгдэл 114,865.0 мянган төгрөг болж, 77,404.5 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гүйцэтгэлээр 4 аж ахуйн нэгжийн он дамжсан газрын төлбөр болох 46,838.6 мянган төгрөг, өмнөх оны газрын төлбөрийн үлдэгдэл 20,500.2 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулсан байна. Газрын төлбөрийн авлагын үлдэгдлийг тулган шалгахад 4 аж ахуйн нэгжийн 10,065.7 мянган төгрөгийн үлдэгдлийг илүү бүртгэсэнг авлагын данснаас хасаж залруулга хийсэн.
- Бараа материалын дансны үлдэгдэл 10,777.4 мянган төгрөг болж 740.8 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 18,034.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 18,775.0 мянган төгрөгийн бараа, материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,282,422.1 мянган төгрөг болж 2,927,747.3 мянган төгрөг буюу 15.1 хувиар өссөн байна. Үүнд:
 - Тайлант онд Алтанбулаг чөлөөт бүсийн Цахилгааны өргөтгөлийн барилгын ажлын санхүүжилтэд олгосон 3,999,999.9 мянган төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэсэн;
 - ТӨБЗГ-ын 2024 оны А-1/1634 дугаар албан тоотын дагуу Эдийн засгийн хөгжлийн яамны балансаас балансад шилжиж ирсэн нийт 11,179.5 мянган төгрөгийн үнэтэй 7,744.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тавилга, эд хогшлыг хөрөнгийн дансанд бүртгэж авсан;
 - ТӨБЗГ-ын 2023 оны 31 дүгээр тогтоолоор бусад биет бус хөрөнгөд бүртгэлтэй Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсэд байрлах газраас нийт 200,164.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг данснаас хасах зөвшөөрөл олгосон байна. Үүнд:
 - Худалдаа үйлчилгээний зориулалтаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч 15 аж ахуйн нэгжүүдэд олгосон 15,723.4 м.кв бүхий газар эзэмших эрхийг нийт 188,680.8 мянган төгрөгөөр үнэлж, данснаас хасах;
 - Тус Захирагчийн ажлын албанд худалдаа үйлчилгээний зориулалтаар олгосон 62000 м.кв талбай бүхий газарт хамруулан давхардуулан бүртгэсэн 957 м.кв талбай бүхий 11,484.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, залруулах;

Тайлант онд нийт 875,523.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

- Өр төлбөр дансны үлдэгдэл 37,799.0 мянган төгрөг болж, 68,717.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны цахилгааны ажлын гүйцэтгэлийн барьцаа 72,200.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 24,544.8 мянган төгрөг, бусад өр төлбөрийн 9,771.7 мянган төгрөгийг төлж, 17 аж ахуйн нэгжийн илүү төлсөн газрын төлбөр 6,719.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 6,240.1 мянган төгрөг, техник хяналтын үлдэгдэл 24,839.6 мянган төгрөгийг байгууллагад өгөх өглөгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22,395,105.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,870,959.1 мянган төгрөгөөр өссөн нь байна. Энэ нь тайлант оны үр дүн

2,887,744.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, нягтлан бодох бодлогын өөрчлөлт 16,785.2 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус чөлөөт бүсийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,707,394.9 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр 12,300,000.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 80,202.0 мянган төгрөг, нийт зарлагыг 16,087,596.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн дээд шатны төсвийн захирагч хянан улсын төсвөөс 1,300,666.3 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр 4,000,000.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 132,064.5 мянган төгрөг, нийт зарлагыг 5,432,730.8 мянган төгрөг буюу 10,654,865.7 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн тодотголыг 1 удаа хийж, томилолтын зардлын 2,790.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 5,435,520.8 мянган төгрөгөөр нийт зардлыг санхүүжүүлэхээр тодотголоор баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,435,520.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,303,456.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 132,064.5 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,303,456.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 173,482.4 мянган төгрөг нийт 5,476,938.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 5,376,458.4 мянган төгрөгийг зарцуулж, 100,480.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,376,458.4 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 57,078.5 мянган төгрөгөөр, бусад зардлыг 1,983.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
	Код	Үзүүлэлт			Зөрүү	Биелэлт
1	71201	Чөлөөт бүсийг хөгжүүлэх	5,435,520.8	5,376,458.4	(59,062.4)	98.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,413,938.8	1,356,402.2	(57,536.6)	95.9
1.2	80219	Харуул хамгаалалтын зардал	11,772.0	11,206.7	(565.3)	95.1
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	9,810.0	8,850.0	(960.0)	90.2
1.4	80918	Бусад/Барилга байгууламж	4,000,000.0	3,999,999.9	(0.1)	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

СНАГ-2025/248/НА-СТА-ТШЗ

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Лидер экаунт аудит ХХК-ийн ахлах аудитор Ш.Уянга, аудитор Ч.Отгонцэцэг, аудиторын туслах Б.Уугантуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер М.Мягмарсүрэн, захирал П.Шаравхорол нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

